



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/185/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Булган аймаг  
2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580  
Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид  
Утас: 9511-2689 Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

Ахлах аудитор Ш.Ганчимэг Утас: 99377360  
Цахим хаяг: [shagdarganchimeg44@jmail.com](mailto:shagdarganchimeg44@jmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12-14
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16-17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	17-18
7. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	19
8. Төлбөрийн акт, 01/149, 02/150, 03/151, 04/152.....	20-23
9. Албан шаардлага, 01/115, 02/116.....	24-25

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 255

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БАЯННУУР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ С.ЦЭРЭНДУЛАМ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 92,369.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Аудитын гол асуудал

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 34,608.1 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж, тодруулсан байна.

006020562

### **Бусад асуудлын хэсэг**

Баяннуур сумын ЕБС-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 23 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 86 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>91,482,596.96</u></b>	<b><u>129,531,049.73</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	51,682,997.68	92,369,319.63
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	51,682,997.68	92,369,319.63
31221	Төрийн сангийн харилцах	51,682,997.68	92,369,319.63
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>400,000.00</b>	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	400,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>39,399,599.28</b>	<b>37,161,730.10</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	<b>286,164.10</b>
35110	Тусгай зориулалттай материал	-	286,164.10
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>39,399,599.28</b>	<b>36,875,566.00</b>
35410	Бичиг хэргийн материал	218,300.00	333,000.00
35420	Аж ахуйн материал	21,956,729.23	20,189,425.95
35460	Хүнсний материал	17,224,570.05	16,353,140.05
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,294,964,408.17</u></b>	<b><u>1,348,325,950.75</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,294,964,408.17</b>	<b>1,348,325,950.75</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,264,810,408.17</b>	<b>1,318,171,950.75</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,429,211,567.49	1,475,211,567.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(259,541,317.46)	(327,472,310.66)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,845,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,707,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,344,660.00	154,487,520.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,827,858.10)	(47,321,238.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,641,855.50	68,369,335.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,145,860.81)	(30,829,343.95)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,370,140.00	38,350,180.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(18,603,267.65)	(19,395,196.77)
39217	Ном	4,222,489.20	6,771,437.70
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>30,154,000.00</b>	<b>30,154,000.00</b>
39301	Програм хангамж	1,700,000.00	1,700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,454,000.00	28,454,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,386,447,005.13</u></b>	<b><u>1,477,857,000.48</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>233,127.20</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>233,127.20</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	<b>233,127.20</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>233,127.20</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	233,127.20
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,386,447,005.13</u></b>	<b><u>1,477,623,873.28</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,386,447,005.13	1,477,623,873.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<b>232,416,592.14</b>	<b>232,416,592.14</b>

51101	Өмч: - төрийн	232,416,592.14	232,416,592.14
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(181,439,716.40)</b>	<b>(90,262,848.25)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(181,439,716.40)	(181,439,716.40)
51220	Тайлант үеийн үр дүн	-	91,176,868.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,335,470,129.39	1,335,470,129.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,386,447,005.13</u></b>	<b><u>1,477,857,000.48</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>876,614,800.00</b>	<b>1,169,884,772.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>131,515,972.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>131,515,972.60</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	131,515,972.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,310,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	130,205,172.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>876,614,800.00</b>	<b>1,038,368,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>875,394,000.00</b>	<b>908,788,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	735,236,700.00	908,788,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	140,157,300.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,220,800.00</b>	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,220,800.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>129,580,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	129,580,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>889,860,210.21</b>	<b>1,072,911,551.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>889,860,210.21</b>	<b>1,072,911,551.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>847,409,629.68</b>	<b>1,024,224,209.29</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>509,739,063.06</b>	<b>628,966,388.62</b>
210101	Үндсэн цалин	372,791,379.41	422,999,941.43
210102	Нэмэгдэл	105,985,892.70	179,620,000.13
210104	Урамшуулал	30,961,790.95	26,346,447.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,852,908.73</b>	<b>85,215,924.84</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,364,950.43	58,350,556.70
210202	Тэтгэмжийн даатгал	5,337,047.00	6,708,511.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,580,671.04	5,366,511.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,940,283.79	1,335,398.65
210205	Эрүүл мэндийн даатгал	10,629,956.47	13,454,945.81
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>107,280,000.00</b>	<b>116,119,536.90</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,230,925.00	3,733,786.90

210302	Түлш, халаалт	99,049,075.00	112,385,750.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>5,117,503.28</b>
210408	Бараа материал акталсны зардал	-	5,117,503.28
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,074,710.00</b>	<b>40,243,430.00</b>
210502	Хоол, хүнс	45,074,710.00	40,243,430.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,580,060.00</b>	<b>7,529,220.11</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,562,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,580,060.00	4,966,820.11
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>113,882,887.89</b>	<b>140,532,205.54</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,521,300.00	39,099,652.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,795,700.00	7,740,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	89,565,887.89	93,692,252.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,450,580.53</b>	<b>48,687,341.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,450,510.00</b>	<b>42,505,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,450,510.00	42,505,600.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>70.53</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70.53	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	<b>6,181,741.85</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,181,741.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(13,245,410.21)</b>	<b>96,973,221.46</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,346,739.75</b>	<b>5,796,353.31</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,346,739.75	5,796,353.31
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(14,592,149.96)</b>	<b>91,176,868.15</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>876,614,800.00</b>	<b>1,039,679,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,310,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	<b>1,310,800.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	<b>1,310,800.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,310,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>876,614,800.00</b>	<b>1,038,368,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>875,394,000.00</b>	<b>908,788,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	735,236,700.00	908,788,800.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	140,157,300.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,220,800.00</b>	-

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,220,800.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	<b>129,580,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	129,580,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>812,941,802.32</b>	<b>976,062,138.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>812,941,802.32</b>	<b>976,062,138.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>765,419,271.79</b>	<b>927,447,496.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>510,139,063.06</b>	<b>628,566,388.62</b>
210101	Үндсэн цалин	373,191,379.41	422,599,941.43
210102	Нэмэгдэл	105,985,892.70	179,620,000.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	30,961,790.95	26,346,447.06
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,852,908.73</b>	<b>85,215,924.84</b>
210201	Тэтгэврийн даатгал	45,364,950.43	58,350,556.70
210202	Тэтгэмжийн даатгал	5,337,047.00	6,708,511.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,580,670.94	5,366,511.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,940,283.79	1,335,398.65
210205	Эрүүл мэндийн даатгал	10,629,956.57	13,454,945.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>107,280,000.00</b>	<b>122,898,258.15</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,230,925.00	10,512,508.15
210302	Түлш, халаалт	99,049,075.00	112,385,750.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>52,882,640.00</b>	<b>39,444,700.00</b>
210502	Хоол, хүнс	52,882,640.00	39,444,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,580,060.00</b>	<b>7,679,220.11</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,562,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,580,060.00	5,116,820.11
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,684,600.00</b>	<b>43,143,004.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,636,400.00	35,087,704.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,048,200.00	8,055,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,522,530.53</b>	<b>48,614,641.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>47,522,460.00</b>	<b>42,432,900.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,522,460.00	42,432,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>70.53</b>	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	70.53	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	<b>6,181,741.85</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,181,741.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>63,672,997.68</b>	<b>63,617,461.95</b>

5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,990,000.00</b>	<b>22,931,140.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,990,000.00</b>	<b>22,931,140.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,990,000.00</b>	<b>22,931,140.00</b>
222001	Тоног төхөөрөмж	11,990,000.00	22,931,140.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,990,000.00)</b>	<b>(22,931,140.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	51,682,997.68	40,686,321.95
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>51,682,997.68</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>51,682,997.68</b>	<b>92,369,319.63</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(181,429,415.44)	1,386,457,306.09
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(181,429,415.44)	1,386,457,306.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,300.96)	(10,300.96)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(181,439,716.40)	1,386,447,005.13
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(181,439,716.40)	1,386,447,005.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(181,439,716.40)	1,386,447,005.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	91,176,868.15	91,176,868.15
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(90,262,848.25)	1,477,623,873.28

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,092,617,500.00</b>	<b>992,811,536.20</b>	<b>99,805,963.80</b>	<b>90.87</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,092,617,500.00</b>	<b>969,880,396.20</b>	<b>122,737,103.80</b>	<b>88.77</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,041,092,200.00</b>	<b>927,447,496.20</b>	<b>113,644,703.80</b>	<b>89.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>709,806,300.00</b>	<b>628,566,388.62</b>	<b>81,239,911.38</b>	<b>88.55</b>
210101	Үндсэн цалин	484,929,900.00	422,599,941.43	62,329,958.57	87.15
210102	Нэмэгдэл	200,985,200.00	179,620,000.13	21,365,199.87	89.37
210104	Урамшуулал	23,891,200.00	26,346,447.06	(2,455,247.06)	110.28
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>88,725,900.00</b>	<b>85,215,924.84</b>	<b>3,509,975.16</b>	<b>96.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	60,333,600.00	58,350,556.70	1,983,043.30	96.71
210202	Тэтгэмжийн даатгал	7,098,000.00	6,708,511.93	389,488.07	94.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,678,500.00	5,366,511.75	311,988.25	94.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,419,600.00	1,335,398.65	84,201.35	94.07
210205	Эрүүл мэндийн даатгал	14,196,200.00	13,454,945.81	741,254.19	94.78
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>128,580,000.00</b>	<b>122,898,258.15</b>	<b>5,681,741.85</b>	<b>95.58</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,712,000.00	10,512,508.15	9,199,491.85	53.33
210302	Түлш, халаалт	108,568,000.00	112,385,750.00	(3,817,750.00)	103.52
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	-	300,000.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>56,625,900.00</b>	<b>39,444,700.00</b>	<b>17,181,200.00</b>	<b>69.66</b>
210502	Хоол, хүнс	56,625,900.00	39,444,700.00	17,181,200.00	69.66
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>50.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,589,600.00</b>	<b>7,679,220.11</b>	<b>(2,089,620.11)</b>	<b>137.38</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,562,400.00	(2,562,400.00)	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,589,600.00	5,116,820.11	472,779.89	91.54
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,764,500.00</b>	<b>43,143,004.48</b>	<b>7,621,495.52</b>	<b>84.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,380,000.00	35,087,704.48	7,292,295.52	82.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,384,500.00	8,055,300.00	329,200.00	96.07
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,525,300.00</b>	<b>42,432,900.00</b>	<b>9,092,400.00</b>	<b>82.35</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,525,300.00</b>	<b>42,432,900.00</b>	<b>9,092,400.00</b>	<b>82.35</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,525,300.00	42,432,900.00	9,092,400.00	82.35
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>22,931,140.00</b>	<b>(22,931,140.00)</b>	
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	<b>22,931,140.00</b>	<b>(22,931,140.00)</b>	
222001	Тоног төхөөрөмж	-	22,931,140.00	(22,931,140.00)	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>1,039,679,600.00</b>	<b>(1,039,679,600.00)</b>	
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	<b>908,788,800.00</b>	<b>(908,788,800.00)</b>	
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	908,788,800.00	(908,788,800.00)	
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	<b>129,580,000.00</b>	<b>(129,580,000.00)</b>	
132001	Орон нутгийн төсвөөс	-	129,580,000.00	(129,580,000.00)	
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	1,310,800.00	(1,310,800.00)	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,310,800.00	(1,310,800.00)	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>51,682,997.68</b>	<b>(51,682,997.68)</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>92,369,319.63</b>	<b>(92,369,319.63)</b>	

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

#### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баяннуур сумын ЕБС нь бүрэн дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд нийт 39 орон тоогоор ажиллаж “Хүүхэд нэг бүрийн тэгж хөгжих боломжийг нэмэгдүүлж, зөв хүмүүжил төлөвшилтэй суралцагчдыг бий болгоход олон талт хамтын үйл ажиллагааг сайжруулна” гэсэн зорилт дэвшүүлж ажиллажээ. Аймгийн засаг даргын "Шинэ зам мөрийн хөтөлбөр"-ийн дэд хөтөлбөр "Шинэ багш", "Шинэ Ирээдүй" хөтөлбөрүүдийг хэрэгжижүүлж байна.

Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 23 арга хэмжээтөлөвлөж, хэрэгжилтийг 86 хувиар тайлагнажээ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол, "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын

нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын ЕБС-ийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91,410.0 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	51,683.0	92,369.3	40,686.3
Авлага	400.0	-	(400.0)
Бараа материал	39,399.6	37,161.7	(2,237.9)
Үндсэн хөрөнгө	1,634,789.7	1,773,344.0	138,554.3
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(339,825.3)	(425,018.1)	(85,192.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>1,386,447.0</u></b>	<b><u>1,477,857.0</u></b>	<b><u>91,410.0</u></b>
Өр төлбөр		233.1	233.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b><u>1,386,447.0</u></b>	1,477,623.9	91,176.9
Өр төлбөр /богино хугацаат/			
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>1,386,447.0</u></b>	<b><u>1,477,857.0</u></b>	<b><u>91,410.0</u></b>

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 92,369.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх үлдэгдлийн 88.0 хувь буюу 81,239.9 мянган төгрөг нь цалингийн зардлаас, 17,181.2 мянган төгрөг нь хүүхдийн хоолны зардлаас зарцуулагдаагүй үлдсэн нь орон тоо дутуу ажилласан, хүүхдийн тооны зөрүүгээс тус тус шалтгаалсан байна.

Тайлант онд 110,880.9 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 108,000.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 5,117.5 мянган төгрөгийн аж ахуйн материал акталжээ. Түрээсийн сурах бичгийн 286.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын материал дансанд хандивын орлогоор бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,773,344.0 мянган төгрөг болж 138,554.3 мянган төгрөгөөр өсчээ. БШУС-ын 2023 оны А/230 дугаар тушаалаар хуваарилсан нөхөн хангалтын санхүүжилтээс 22,931.1 мянган төгрөгөөр сургалтын тоног төхөөрөмжийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжид нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллажээ. Мөн БШУЯ, ОНХС, эцэг эхийн хандиваар 52,728.4 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, бүртгэлд тусгасан байна. –

Нийт 14,295.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсанаас 6,450.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 7,845.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж бүртгэжээ.

Тайлант хугацаанд 93,692.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,477,623.9 мянган төгрөг болж 91,176.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 293,270.0 мянган төгрөгөөр буюу 27.1 хувиар өсөхөд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө өмнөх оноос 131,516.0 мянган төгрөгөөр, санхүүжилтийн орлого 161,754.0 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 183,051.4 мянган төгрөгөөр өсчээ. Үүний 75.1 хувь буюу 137,516.0 мянган төгрөг нь цалин, хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл байна.

### **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2023 оны төсвийг 873,380.0 төгрөгөөр баталсныг тайлант онд 2 удаа өөрчлөлт оруулж, тодотгон оны эцэст 908,788.8 мянган төгрөгөөр буюу 35,408.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 908,788.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 129,580.0 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,039,679.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 92,369.3 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
<b>71802 Ерөнхий боловсрол</b>	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,577.5	2,235.6	1,341.9	
	2	80312- Сургалт семинар	1,676.9	1,090.0	586.9	
	3	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,235.9	2,200.0	35.9	
	4	81801- Үдийн цай хөтөлбөр	74,852.0	42,432.9	32,419.1	
	5	81806-Дотуур байрны хүүхдийн хоол	125,772.4	62,764.6	63,007.8	
	6	81816- Зөв монгол хүүхэд үн хөтөлбөр	28,316.3	3,285.3	25,031.0	
	7	81823- Боловсролын багшийн сургалт	9,055.3	4,986.0	4,069.3	
	8	81834- Боловсролын стандарт сургалт	885,386.8	575,810.4	309,576.4	
	9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	213,029.6	134,486.5	78,543.1	
	10	81848 – гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчин				

	11	81848-Сурах бичгийн түрээс		2,562.4	(2,562.4)	
	12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	185,280.9	123,398.3	61,882.6	
<b>Нийт</b>			<b>1,039,679.6</b>	<b>947,310.3</b>	<b>92,369.3</b>	<b>91.1</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяннуур сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн ахлах аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ЦЭСБ аудит ХХК-ийн захирал Ч.Цэрэннадмид хэрэгжүүлж дараагийн хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын ЕБС нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 889,860.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,898.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 70 хувиар тооцон 6,229.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад хуулиар хориглосон асуудлыг санхүүжүүлээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Баяннур сумын ЕБС-ийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материалын зарцуулалт, төсвийн зарцуулалттай холбоотой асуудлыг хянахаар тусгайлан авч үзсэн. Аудитаар ур чадварын нэмэгдлийг олгохдоо тухайн багшийн манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй, илүү хувиар тооцож олгосон зөрчилд 919.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, ур чадварын нэмэгдлийг олгохдоо тухайн багшийн манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй зөрчилд 3,163.5 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн.

Дотуур байрны хүүхдийн хоолны өдөрлөгт бичигдсэн хүүхдийн тоог баталгаажуулаагүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар шилэн дансны мэдээлэлд тушаал шийдвэрийг дутуу мэдээлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	1	0	1	0	0
Зөвлөмж					

Нийт дүн	1		1		100
----------	---	--	---	--	-----

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 3,357.7 мянган төгрөгийн алдааг залруулж, нийт 7,261.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,898.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 5,363.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Аудитын явцад шууд зардлаар тайлагнасан цаашид ашиглагдах тусгай зориулалтын бараа материалыг үлдэгдлээр тусгуулж, залруулга хийлгэсэн.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Багш М.Эрдэнэ-Очирт 9 дүгээр сарын цалингийн тооцоонд ур чадварын нэмэгдлийг давхардуулан 127.3 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4.3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно” гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.

2. Захирал С.Цэрэндуламд сумын Засаг даргын захирамжаар 751.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Боловсролын ерөнхий газрын даргыг сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчаар томилсон, БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгосон бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшуулал давхар шийдэгдсэн тул төлбөрийн акт тогтоосон.

3. Өмнөх оны цалингийн авлагыг бүрэн барагдуулаагүй үлдэгдэл 100.0 мянган төгрөгийг тайлант оны цалингийн зардалд хаасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон.

4. Багш, ажилтны ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй, илүү хувиар тооцож 919.7 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4.3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож,

сар бүр олгоно” гэсэн заалтыг зөрчсөн тул Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

1. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж, 2,200.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, Эрүүл мэндийн сайдын 2022 оны хамтарсан А/328, 1/340 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах” тухай журмын 1-д заасан “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалт”-ыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

Багш нарын ур чадварын нэмэгдэлд 3,163.5 мянган төгрөг олгохдоо тухайн багшийн манлайлал, мэргэжлийн ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, ХНХС, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалын 4-т “Шалгуур үзүүлэлтийн 3-т заасан нийтлэг шалгуурыг хангасан ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ” гэж заасантай нийцэхгүй байна. Иймд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “Төсвийг зориулалт бусаар зарцуулсан”, 4.2.1.8-д “Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлсэн.

## 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй болно.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			Тоо	Дүн
							Тоо	Дүн	Дүн	Тоо	Дүн		
Шууд зардлаар тайлагнасан цаашид ашиглагдах тусгай зориулалтын бараа материалыг үлдэгдлээр тусгуулсан.	1	3,357.7			1	3,357.7	1	3,357.7					
Дүн	1	3,357.7	-		1	3,357.7	1	3,357.7	-	-	-	-	-



